



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар E/14

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Зөвшилцөх санал хүргүүлэх тухай

Довчинсүрэнгийн Ганзориг нь өөр ажилд томилогдож байгаатай холбогдуулан албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11.1.10 дахь заалтыг үндэслэн Сүнрэвийн Ганбямбыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар томилох саналыг зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

2022000073



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГАД НЭР ДЭВШИГЧ
БРИГАДЫН ГЕНЕРАЛ СҮНРЭВИЙН ГАНБЯМБЫН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сунрэв овогтой Ганбямба нь 1975 онд Улаанбаатар хотод төрсөн. 47 настай.

Боловсрол, мэргэжил:

- 1983-1993 онд Нийслэлийн 33 дугаар дунд сургуульд суралцан, бүрэн дунд боловсрол эзэмшсэн.
- 1993-1997 онд Цэргийн их сургуульд суралцаж, “Артиллерийн команд-тактик”-ийн мэргэжил эзэмшин Цэргийн ухааны бакалаврын зэрэгтэй төгссөн.
- 2007-2009 онд Батлан хамгаалахын удирдлагын академид суралцан, “Стратеги-тактик, команд штаб”-ын мэргэжил эзэмшиж, Цэргийн ухааны магистрын зэрэгтэй, “Онцгойлох үнэлгээтэй” төгссөн.
- 2017-2019 онд Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын академид суралцаж “Төрийн цэргийн аюулгүй байдал” мэргэжлээр төгссөн.
- Одоо ҮБХИС-ийн докторантурт суралцаж байна.

Бригадын генерал С.Ганбямба нь Бүгд Найрамдах Турк Улсад 2003 онд “Энхийг сахиулах ажиллагааны анхан шатны дамжаа”, 2006 онд “Батальоны захирагчийн дамжаа”-г тус тус төгссөн. Мөн 2014 онд Канад Улсад “Англи хэлний анхан шатны дамжаа”-г дүүргэсэн. Орос, турк, англи хэлний зохих мэдлэгтэй.

Ажлын туршлага:

- 1997-2000 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангид салааны захирагч;
- 2000-2001 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангид батарейны захирагч;
- 2001-2006 онд Батлан хамгаалахын их сургуулийн Ахлагчийн сургуульд ротын захирагч;
- 2006-2007 онд Зэвсэгт хүчний 327 дугаар ангид артиллерийн дарга;
- 2009-2012 онд Батлан хамгаалахын удирдлагын академийн Цэргийн стратегийн тэнхимд багш, ахлах багш;
- 2012-2013 онд Батлан хамгаалах яаманд тасгийн дарга, ахлах мэргэжилтэн;
- 2013-2017, 2019-2020 онуудад Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга;
- 2020-2021 оны 9 дүгээр сард Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

- 2021 оны 9 дүгээр сараас Зэвсэгт хүчний Жанжин штабын 1-р орлогч даргаар томилогдон ажиллаж байна.


2010-2011 онд Афганистан улсад Артиллерийн сургалтын хөдөлгөөнт багийн 11 дүгээр ээлжийн багийн захирагчаар үүрэг гүйцэтгэсэн.

С.Ганбямба нь Цэргийн их сургууль, Батлан хамгаалах удирдлагын академи, ОХУ-ын Жанжин штабын академийг төгсөж, цэргийн боловсролын хувьд оператив-стратегийн түвшинд ажиллах шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд Зэвсэгт хүчний анги байгууллага, Цэргийн сургууль, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагад шат дараалан ажилласан дадлага, туршлагатай, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг удирдан оролцсон, Зэвсэгт хүчинд тасралтгүй 29 жил албаа нэр төртэй хааж буй тэргүүний дээд офицер юм.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бригадын генерал С.Ганбямбыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар томилуулах саналыг Улсын их хуралтай зөвшилцөхөөр хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА



Я.СОДБААТАР

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АНКЕТ
"А ХЭСЭГ"**

Нэг.Хувь хүний талаарх мэдээлэл

Регистрийн дугаар:

ЦБ 75111577

1.1 Иргэншил: Монгол

1.2.Ургийн овог: Олныхон

1.3.Эцэг (эх)-ийн нэр: Сүнрэв

1.4.Өөрийн нэр: Ганбямба 1.5.Хүйс: эр

1.6.Төрсөн:

1.7.Төрсөн аймаг, хот, улс: Улаанбаатар сум, дүүрэг: Сүхбаатар

Төрсөн газар: Нэгдүгээр төрөх газар

1.8.Үндэс, угсаа: халх

1.9.Гэр бүлийн байдал (зөвхөн гэр бүлийн бүртгэлд байгаа хүмүүсийг бичнэ):



| Таны юу болох | Гэр бүлийн гишүүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр | Төрсөн он | Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг | Одоо эрхэлж буй ажил |
|---------------|--|-----------|--------------------------------|--|
| эхнэр | Өлзийбаяр Жавзандулам | 1980 | Улаанбаатар, Найрамдал | Цэргийн тэтгэвэрт |
| хүү | Ганбямба Хүсэлбадрах | 2005 | Улаанбаатар, Баянгол | MIU дунд сургууль 12-р ангийн сурагч |
| хүү | Ганбямба Буянбадрах | 2009 | Улаанбаатар, Баянгол | 14-р сургууль 8-р ангийн сурагч |
| охин | Ганбямба Жаргал-Ундрах | 2014 | Улаанбаатар, Баянгол | Плехановын нэрэмжит 10 жилийн сургууль 3-р ангийн сурагч |
| охин | Ганбямба Заяадэлгэрэх | 2020 | Улаанбаатар, Баянгол | гэрт |

1.9.Садан төрлийн байдал (Таны эцэг, эх, төрсөн ах, эгч дүү, өрх тусгаарласан хүүхэд)

| Таны юу болох | Садан төрлийн хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр | Төрсөн он | Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг | Одоо эрхэлж буй ажил |
|---------------|--|-----------|--------------------------------|--|
| эцэг | Гомбо Сүнрэв | 1951 | Сүхбаатар, Мөнххаан | тэтгэвэрт |
| эгч | Сүнрэв Гантөмөр | 1973 | Хэнтий, Өндөрхаан | хувиараа бизнес эрхлэгч |
| дүү | Сүнрэв Төмөрсүх | 1979 | Улаанбаатар, Найрамдал | ЗХ-ний 016-р анги нягтлан бодогч |
| дүү | Сүнрэв Баярмагнай | 1985 | Улаанбаатар, Найрамдал | ЗХ-ний 016-р анги салааны захирагчийн орлогч |
| дүү | Сүнрэв Оюунчимэг | 1988 | Улаанбаатар, Найрамдал | хувиараа бизнес эрхлэгч |

1.10. Оршин суугаа хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг

Гэрийн хаяг: 16 хороолол, ХД66 байр, 23 тоот

Утас, үүрэн утас: 99261912 Факс..... И-мэйл хаяг: ganbyamba@mod.gov.mn

1.11.Зайлшгүй шаардлагатай холбоо барих хүн:

Нэр: Ө.Жавзандулам /эхнэр/, Утас: 95821216

Хоёр. Ур чадварын талаарх мэдээлэл

2.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалтын талаарх мэдээлэл

| Мэдээний агуулга | Тайлбар |
|----------------------------|---------|
| Ерөнхий шалгалт өгсөн эсэх | - |
| Тусгай шалгалт өгсөн эсэх | өгсөн |
| Нөөцөд байгаа эсэх | - |

(*Шалгалт өгсөн эсэх гэсэн хэсэгт ерөнхий болон тусгай шалгалт "өгсөн" гэх, өгөөгүй бол "өгөөгүй гэж" бичнэ.)

Гурав. Боловсролын талаарх мэдээлэл

3.1. Боловсрол (Суурь боловсрол, дипломын дээд боловсрол, бакалавр, магистрын зэргийг оролцуулан)

| Сургуулийн нэр | Орсон он, сар | Төгссөн он, сар | Эзэмшсэн мэргэжил, | Гэрчилгээ, дипломын дугаар |
|---|---------------|-----------------|--|----------------------------|
| Нийслэлийн 33 дугаар дунд сургууль | 1983.09 | 1993.06 | Бүрэн дунд | 786098 |
| Цэргийн их сургууль | 1993.07 | 1997.07 | Артиллерийн команд, Цэргийн ухааны бакалавр | 034739 |
| Батлан хамгаалахын удирдлагын академи | 2007.09 | 2009.07 | Стратеги-тактик, команд штаб, Цэргийн ухааны магистр | E20093894 |
| ОХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын академи | 2017.10 | 2019.06 | Төрийн цэргийн аюулгүй байдал | 772407254033 |

(*Сургуулийн нэрийг бүтэн бичнэ)

3.2.Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг

| Зэрэг | Хамгаалсан газар | Он, сар | Гэрчилгээ, дипломын дугаар |
|-------|------------------|---------|----------------------------|
| | | | |

Боловсролын доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан сэдэв:

Шинжлэх ухааны доктор (ScD)-ын зэрэг хамгаалсан сэдэв:

Дөрөв.Мэргэшлийн талаарх мэдээлэл

4.1.Мэргэшлийн бэлтгэл (Мэргэжлээрээ болон бусад чиглэлээр нарийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдлыг бичнэ)

| Хаана, дотоод, гадаадын ямар байгууллагад | Эхэлсэн дууссан он, сар, өдөр | Хугацаа /хоногоор | Ямар чиглэлээр | Үнэмлэх: гэрчилгээний дугаар, он, сар, өдөр |
|---|-------------------------------|-------------------|-------------------------------|---|
| БНТУ | 2003.04-08 | 120 | Энхийг дэмжих ажиллагаа | |
| БНТУ | 2006.06-07 | 30 | Батальоны захирагчийн дамжаа | |
| Боловсролын их сургууль | 2011.12 | 10 | Багшлах мэргэжил олгох дамжаа | 037/12 2012.01 |
| Удирдлагын академи | 2013.04 | 3 | Бодлого боловсруулалт | 13/0715 2013.05 |

| | | | | |
|--------------------|------------|----|---|----------------|
| Канад | 2014.01-03 | 69 | Англи хэл | |
| БНТУ | 2015.04-05 | 14 | Эрсдлийн удирдлага, төлөвлөлт | |
| БНИТУ | 2016.04 | 5 | НАТО-гийн түншлэгч орнуудад чиг баримжаа олгох дамжаа "IROC-2016/1" | |
| Удирдлагын академи | 2019.12 | 5 | Төрийн захиргааны Эрхэлсэн түшмэл | E0242, 2019.12 |

4.2.Эрдмийн цол (дэд профессор, профессор, академийн гишүүнийг оролцуулан)

| Цол | Цол олгосон байгууллага | Огноо | Гэрчилгээ, дипломын дугаар |
|-----|-------------------------|-------|----------------------------|
| | | | |

Тав.Цэргийн алба хаасан эсэх

| | |
|------------------------|--------|
| Цэргийн алба хаасан | хаасан |
| Цэргийн алба хаагаагүй | |

| д/д | Цэргийн үүрэгтний үнэмлэхний дугаар | Цэргийн алба хаасан байдал | Тайлбар |
|-----|-------------------------------------|----------------------------|---------|
| 1 | Офицерын үнэмлэх №275 | офицер | |

(Цэргийн алба хаасан бол дээрх мэдээллийг бөглөнө)

Зургаа. Шагналын талаарх мэдээлэл (Төрийн дээд шагнал, Засгийн газрын шагнал болон салбарын бусад шагналыг бичнэ)

| Шагнагдсан огноо | Шагналын нэр | Шийдвэрийн нэр, огноо дугаар | Шагнуулсан үндэслэл |
|------------------|--------------------------------------|------------------------------|--|
| 2001.03.12 | Дайчин алдар-3 | БХС-ын тушаал №80 | Ажилдаа амжилт гаргасан. |
| 2007.03.14 | Дайчин алдар-2 | БХС-ын тушаал №60 | |
| 2010.03.17 | Цэргийн хүндэт медаль | Ерөнхийлөгчийн зарлиг №45 | |
| 2011.05.13 | Энхийн төлөө | Ерөнхийлөгчийн зарлиг №93 | Афганистанд ЭДА-нд амжилттай оролцсон. |
| 2014.03.14 | Дайчин алдар-1 | БХС-ын тушаал №Б/83 | Ажилдаа амжилт гаргасан. |
| 2015.12.21 | Цэргийн гавъяаны одон | Ерөнхийлөгчийн зарлиг №188 | |
| 2016.07.08 | Засгийн газрын хүндэт өргөмжлөл | Ерөнхий сайдын захирамж | |
| 2017.09.24 | Батлан хамгаалах яамны хүндэт тэмдэг | БХС-ын тушаал № | |
| 2021.03.15 | Цэргийн гавъяаны улаан тугийн одон | Ерөнхийлөгчийн зарлиг №15 | |

Долоо.Туршлагын талаарх мэдээлэл

7.1.Ажилласан байдал

| *Ажилласан байгууллагын нэр | Газар, хэлтэс, алба | Эрхэлсэн албан тушаал | Ажилд орсон он, сар (тушаалын дугаар) | Ажлаас гарсан он, сар (тушаалын дугаар) |
|-----------------------------|---------------------|-----------------------|---------------------------------------|---|
| | | | | |

| | | | | |
|--------------------------------|--|------------------------|--|---------|
| Зэвсэгт хүчний 120 дугаар анги | Сургуулийн АДН | Салааны захирагч | 1997.07 ЗХЖШ-ын даргын №486 | 2000.06 |
| Зэвсэгт хүчний 120 дугаар анги | Сургуулийн АДН | Батарейны захирагч | 2000.06 ЗХЖШ-ын даргын №368 | 2000.12 |
| Батлан хамгаалахын их сургууль | Ахлагчийн сургууль | Ротын захирагч | 2000.12 ТНБД-ын № | 2006.07 |
| Зэвсэгт хүчний 327 дугаар анги | Штаб | Артиллерийн дарга | 2006.08 ЗХЖШ-ын даргын №696 | 2007.07 |
| Батлан хамгаалахын их сургууль | Батлан хамгаалахын удирдлагын академи | Багш | 2009.07 ТНБД-ын №548 | 2012.04 |
| Батлан хамгаалах яам | Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар | Тасгийн дарга | 2012.04 ТНБД-ын Б/72 | 2012.12 |
| Батлан хамгаалах яам | Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар | Ахлах мэргэжилтэн | 2012.12 ТНБД-ын Б/266 | 2013.12 |
| Батлан хамгаалах яам | Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар | Хэлтсийн дарга | 2013.12 ТНБД-ын Б/276 | 2017.09 |
| Батлан хамгаалах яам | Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар | Хэлтсийн дарга | 2019.07 ТНБД-ын Б/206 | 2020.07 |
| Батлан хамгаалах яам | Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар | Газрын дарга | 2020.07 ТНБД-ын Б/222 | 2021.09 |
| Зэвсэгт хүчний Жанжин штаб | | Нэгдүгээр орлогч дарга | 2021.09 МУ-ын Ерөнхийлөгчийн №28 зарлиг | |

(*Байгууллагын нэрийг бүтнээр бичнэ)

Найм. Бүтээлийн жагсаалт

| № | Бүтээлийн нэр | Бүтээлийн төрөл | Бүтээл гаргасан огноо | Тайлбар |
|---|-------------------------------------|-----------------|-----------------------|--------------------------------|
| 1 | Офицер, ахлагчийн лавлах | Гарын авлага | 2010 | Хамтран зохиогч Д.Доржготов |
| 2 | Операц, байлдаанд цэргийн удирдлага | Ном | 2021 | Хамтран зохиогч доктор Б.Түмэн |

("Тайлбар" хэсэгт гадаад хэлнээс орчуулсан болон хамтран зохиогчийн тухай тэмдэглэнэ.)

Анкетаа үнэн бичсэн:

Сүнрэв

/Эцэг (эх)-ийн нэр/

Ганбямба

/өөрийн нэр/

/Гарын үсэг/

Огноо: 2022.10.05

